



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 4/22

Хэрлэнбаян-Улаан

Хууль хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 08-ны өдрийн А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 10 дугаар сарын 10-аас 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд тосгоны хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах, 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа талбайд худалдаа үйлчилгээ ажиллуулахыг хориглосугай.

2. Дээрх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлэл хүргэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (дэслэгч Б.Хангай)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (С.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ж.МАРТ